


Сайхан сумын элс бүхий талбайн хэв шинж болон түүний өөрчлөлт

Сэлэнгэ аймгийн Сайхан сум нь Элсний мужлалын ангиллаар Сэлэнгэ-Туул голын мужийн Орхон-Цээл-Дүрс нарсны дэд мужид хамаарагдах ба салхи-голын гарал үүслийн хэв шинжид багтана [1].

Дүрс нарсны элс нь Хараа голын хөндийд Их (1241), Бага (1235) Номгон уулуудын зүүн хойд дор, Улаанбаатар-Дарханы төмөр замын Салхит өргтөтэй харалдаа, Хараа голын баруун захаар урдаас хойш 20 гаруй км сунаж тогтоно. Урд хэсгээс бусад ихэнх хэсэг нь Хараа голын аллювийн тэгш тал дээр орших учир гипсометрийн хувьд ижил түвшинтэй молцог, далангуудаас тогтсон, нэлэнхүйдээ нарс (*Pinus L.*), бургасаар (*Salix L.*) бэхлэгдсэн үзэсгэлэнтэй тарамцаг болно. Тус дэд районы нийт элс нь 91.3 км² бөгөөд Монгол орны хойт хэсгийн (Хангайн) хэмжээнд тархсан элсний 6 хувийг, улсын хэмжээнд 0.2 хувийг тус тус эзэлнэ [2].

Бид элсний ялгаварын нормчилсон индексийг Ландсат 7 болон 8 дугаар хиймэл дагуулын мэдээг ашиглан бодуулахад дараах үр дүн гарч байна. (1 дүгээр зураг).



Дээрх зураглалаас харахад элс бүхий талбайн ерөнхий хэлбэрүүд нутгийн хойд


1 дүгээр зураг. Сайхан сумын 2003 болон 2018 оны элс бүхий талбай

хэсэгт өөрчлөлтгүй харин Номгоны хөндийн зүүн талаарх районд элсний хуримтлалын томоохон хэлбэр нь тарамцаг хэлбэрт шилжиж элсэрхэг газрын талбай тэлсэн нь харагдаж байна (1 дүгээр хүснэгт).

1 дүгээр хүснэгт. Сайхан сумын элс болон элсэрхэг газрын талбайн өөрчлөлт

| Он | 2003 | 2018 | Өөрчлөлт |
|----------------|-----------------------------------|------|----------|
| | Талбайн хэмжээ (км ²) | | |
| Элс | 19.1 | 17.6 | - 1.5 |
| Элсэрхэг газар | 67.3 | 83.6 | + 16.3 |

2003 болон 2018 оны хооронд нийт 15 жилийн хугацаанд элсний талбай 1.5 км² –аар багассан, харин элсэрхэг газрын талбай 16.3 км² –аар нэмэгдсэн байна (1 дүгээр тахирмаг). Энэ нь байгаль цаг уурын болон нийгмийн хүчин зүйлийн нөлөөн дор үйлчлэл явагдсантай холбоотой хэмээн таамаглаж байна. Тухайлбал, малын тоо толгой болон газар тариалангийн талбай хэт өссөн, агаарын температур олон жилийн дундажаас нэмэгдэн хур тунадас багассан зэрэг болно. Сумын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь Бүрэнгийн нурууны салбар хаяа нам уулс, түүний бэл хөндий зонхилох ба хөрсний хувьд нунтаг карбонатлаг ба карбонатгүй нимгэн хар хүрэн хөрс тархсан байна.




Бид дээрхи зураглалд илэрсэн элс бүхий талбайг шалгах зорилгоор хээрийн судалгаагаар координат авч хилийн тодорлыг давхцуулсан (2 дугаар зураг).

1. Жамбуухай толгойн зүүн талын хөндийд байрлах бүрхэвч элс



2 дугаар зураг. Дүрс нарсны элсний хэсэг тархалт

Тус сумын нутаг дэвсгэрт тархсан элс нь ерөнхий хуримтлалын хувьд ихэнх талбайд бүрхэвч, довцог, молцог, далангийн хэлбэрүүд тархжээ.



2 дугаар зураг. 1984 оны Байрзүйн зурагт Дүрс нарсны элс дүрслэгдсэн байдал

Дээрх хэлбэрийн элсийг дэлгэрүүлбэл: Бүрхэвч элс их төлөв талархаг газар, долгиот тал, ухаа гүвээрхэг гадарга ба бэлийн хэвгий талыг харьцангуй тэгш үеэр хучиж тогтсон байдаг. Бүрхэвч элсний зузаан төдийлөн их биш, дунджаар 10-60см, хааяа 1м хүрэх ба ихэнхдээ өвслөг, сөөгөнцөр ургамлаар, зарим тохиолдолд харгана, буйлс, заг зэрэг сөөглөг ургамлаар бэхлэгдсэн буюу тэдгээрт бэхжсэн байдаг. **Тус элсний өөр нэг хэлбэр бол төгс ургамалжсан дарагдмал байдалтай бүрхэвч элс юм. Ийм төрлийн элстэй газрын ургамал бүрхэвчийг зүй бус хөндөх, бэлчээрт сэлгээгүй давтан давтан ажиглах, нүх шуудуу ухаж сэндийчих зэргээр өнгөн хөрсийг гэмтээхээс байнга сэргийлж аж ахуй, зам тээвэрт ашиглахдаа онцгой болгоомжтой, зөв харьцах, өөрөөр хэлбэл ашиглалт хамгаалалтыг зохистой хослох шаардлагатай. Эс тэгвэл элс нь сулран хийсч өргөн уудам нутаг бэлчээр элсжих цөлжих аюултай болно.**

Дов, овоо хэлбэртэй, төдийлөн өндөр биш (1-4м), салхин талын болон салхины доод талын хажуу нь морфологийн ялгаваргүй, дугуй буюу бага зэрэг сунасан плантай элсэн хуримтлалын эерэг хэлбэрийг довцог элс гэнэ.

Хэмжээгээр довцогоос том, ургамалжсан элсэн толгодыг молцог гэнэ. Молцгийн план нь зөв биш хэлбэртэй, өндөр нь 4м-ээс дээш, салхины доод талын хажуу нь морфологийн тодорхой ялгаваргүй налуу бөгөөд мод, бут, сөөгөнд бэхжсэн салангид байдалтай байхаас гадна ухаа гүвээрхэг толгодлог ул суурийг хучиж үргэлжилсэн, нэлэнхүй тархалттай ч байна [2].

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. [1] – Монгол Улсын Үндэсний Атлас, 2006
2. [2] - Баасан , Т. (2003). Монгол орны элс. Улаанбаатар: Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх үйлдвэр.
3. Loadmap.net
4. Glovis.usgs.gov